

- 3.1.10. Сургалт, дасгалжуулалт явуулах, гадаадын өндөр ур чадвартай тамирчдыг урьж авчрах нөхцлийг бүрдүүлэх;
- 3.1.11. Төр, олон нийтийн болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, нөхөрсөг, уулзалт, хамтарсан тэмцээн, уралдаан зохион байгуулах;
- 3.1.12. Олон улсын чанартай тэмцээн, уралдааныг эх орондоо зохиох боломжийг бүрдүүлсэн сургалтын бааз, тоног хэрэгсэлийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран бий болгох, бий болгох санаачлага гаргах;
- 3.1.13. Дүрмийн зорилгод нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;
- 3.1.14. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр уулын спортыг сурталчилах, сонирхогчдыг хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай нягт хамран ажиллах;
- 3.1.15. Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах;

### **ДӨРӨВ. ХОЛБООНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1. Уулын спорт сонирхогч, хичээллэгч, дэмжигчид болон тамирчин дасгалжуулагч, шүүгчдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдан чиглүүлэх хүрээнд:
  - 4.1.1. Уулын спортыг хөгжүүлэхэд баримтлах, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
  - 4.1.2. Тамирчид, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, судлаач, сонирхогч, дэмжигчдийн уулын спортыг хөгжүүлэхтэй холбоотой хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
  - 4.1.3. Холбооны дүрмийг боловсруулах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэн өөрчилж сайжруулах;
  - 4.1.4. Амжилт гаргасан баг тамирчин, дасгалжуулагчдыг шагналд тодорхойлоходоо амжилт тушлагыг шударгаар үнэлж, тэгш эрхтэйгээр хүсэлтүүдийг хүлээн авч нээлттэй ажиллана.
  - 4.1.5. Холбооны дүрэм, бусад холбогдох дотоод дүрэм журамдаасан хэм хэмжээг зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон тамирчны тэмцээнд оролцох, дасгалжуулагч, шүүгчийн ажиллах эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эрхийг хасах зэрэг ёс зүйн хариуцлага ногдуулах;
  - 4.1.6. Нийслэл, орон нутгийн биеийн тамир, спортын газар, клубуудыг мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмж, гарын авлага, мэдээ, мэдээллээр хангах, үйл ажиллагаа явуулахад нь мэргэжлийн боловсон хүчин, материаллаг баазаар хангах ажлыг зохион байгуулах;
  - 4.1.7. Гишүүд, уулынспортын аялагч клубын Холбооноос гаргасан дүрэм, Мурмын хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих.
- 4.2. Уулын спортын сургалт, судалгааны ажлын хүрээнд:
  - 4.2.1. Сургалт, дасгалжуулалтын арга зүйг боловсронгуй болгох, орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилт, сургалтын техник хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
  - 4.2.2. Уулын спортыг хөгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, түүний үр дүнг сургалт дасгалжуулалтанд ашиглах, бодит нөхцөл, боломжийг бүрдүүлэх;